

**ГУРАВ.ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН
2026 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨЛ, 2027-2028 ОНЫ
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**



3.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

3.1.1. Хууль эрх зүйн хэрэгжилтийг хангаж ажилласан байдал

Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан холбогдох журмын хэрэгжилтийг хангаж, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, иргэдэд чанартай эмнэлгийн тусламж үзүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн 2026 оны төсвийн төслийг боловсруулав.

3.1.2. 2026 онд баримтлах төсвийн бодлого

1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллана.

- Стратегийн худалдан авагч байгууллагын хувьд даатгуулагчдад шаардлагатай эмнэл зүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг батлагдсан төсвийн хүрээнд худалдан авч, санхүүжүүлнэ;
- Даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ;
- Эмнэл зүйн хувьд үр дүн багатай хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ болон давхардсан оношилгоо, шинжилгээг үе шаттайгаар бууруулна;
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ;
- Сангийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана;
- Тусламж, үйлчилгээний өртгийн тооцооллыг цахимжуулна.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Эрүүл мэндийн тогтолцооны үндсэн түвшин болох анхан шатлалын тусламжийг сайжруулахад чиглэсэн стратегийг баримлан эрүүл мэндийн салбарын үр ашигтай, тогтвортой ажиллагааг хангах үндэс суурийг бүрдүүлнэ;
- Даатгуулагчдад эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй, санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна;
- Олон улсын эмнэл зүйн удирдамжийн UpToDate платформын ашиглалтыг сайжруулна;
- Эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгоно;

- Даатгуулагчдад шаардлагатай тусламж, үйлчилгээг бүс нутгийн онцлог байдал, тусламж үйлчилгээний төвлөрөл сааруулах бодлоготой уялдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулна;
- Эрүүл мэндийн байгууллагын чадамжид суурилсан гэрээлэлтийг хийж, гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавина;

3. Даатгуулагчийг өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд огт хамрагдаагүй иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах замаар эрт илрүүлэг үзлэгийн хамралтыг нэмэгдүүлнэ;
- Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн салангид багцуудыг холбогдох тогтоол журмыг шинэчилж, нэгдсэн цахим мэдээллийн санг үүсгэнэ;
- Эрт илрүүлэг үзлэгээр илэрсэн өвчлөлийг эмчлэх, байнгын эмчийн хяналтад байлгаж эргэх холбоог бий болгоно.

3.1.3. Эрүүл мэндийн даатгалын орлого бүрдүүлэлт, шимтгэлийн хувь

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх шимтгэлийн хувь, хэмжээг тооцохдоо “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэв.

- Хөдөлмөр, нийгмийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792,000 төгрөгөөр тооцсон.
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тооцсон.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын шимтгэлийн хэмжээг (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792 000 төгрөг) 2 хувиар тооцсон.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцлийн үзүүлэлтийг сайжруулах зорилгоор тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан зэрэг төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн хэмжээг (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792 000 төгрөг) 2 хувиас 3 хувь болгон нэмэгдүүлэн тооцсон.
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг (Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792 000 төгрөг) 4 хувиар тооцсон.

3.1.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тооцооллын зарчим


3.1.4.1. Орлогын тооцоолол

Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх, ажиллагсдаас төлөх, төсөвт байгууллагаас төлөх, сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогыг тооцохдоо 2020-2025 оны цалингийн сангийн гүйцэтгэлд үндэслэн тооцов. Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг эрүүл мэндийн даатгалын цахим системд бүртгэгдсэн 2024 оны жилийн эцсийн статистик мэдээлэлд үндэслэн тооцоолсон. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт төр шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогын хүрээнд шимтгэлийн хувь хэмжээг **3 хувьд** хүргэх бодлого баталсан бөгөөд үүнийг үндэслэж шимтгэл ногдуулах хувь хэмжээг нэмэгдүүлж тооцсон.

Шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх хэрэгцээ, шаардлага:


1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, тухайн даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардлын эзлэх хувиар харьцуулан гаргахад 2024 оны байдлаар ажил олгогчийн орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь даатгалын сангийн орлогын 42.4 хувийг бүрдүүлж, сангийн зардлыг 7.9 хувийг хүртсэн байна. Гэтэл төр хариуцах иргэд нь даатгалын сангийн орлогын 16.8 хувийг бүрдүүлж, сангийн зардлын 41.9 хувийг хэрэглэж байна. Энэ нь хэдийгээр “эв санааны зарчим”-д суурилж байгаа ч цаашид тэнцвэрт байдлыг хангах чухал байна.

Зураг 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг даатгуулагчийн нэр төрлөөр, болон даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулсан зардал



2. Төр шимтгэлийг нь хариуцах иргэдэд 0-18 насны хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх (эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч болон ял эдэлж байгаа ялтан хамаардаг, нийт 2,2 сая гаруй иргэний шимтгэлийг төрөөс хариуцдаг. Төрөөс олгож буй шимтгэлийн орлого болон эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулж буй зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2024 онд 111.5 тэрбум төгрөгийн орлого орж, 678.4 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байгаа бөгөөд зардал нь бүрдүүлж буй орлогоос 2.7 дахин их байна.

Зураг 3. Төрөөс олгож буй шимтгэлийн орлого, ЭМДС-аас зарцуулж буй зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/




3. БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1981 оны нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн дагуу ОХУ-ын иргэн Монгол Улсын иргэний адилаар авч үзэхээр тусгасан байдаг. Уг хэлэлцээрийн хэрэгжилт хангалтгүй байгааг ОХУ-аас Гадаад харилцааны яаманд ирүүлсэн нот бичигт дурдсан байна. Эдгээр хэрэгжилт хангалтгүй байгаа асуудлын дунд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төр хариуцан төлөх даатгуулагчид хамаарах хүүхэд, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай Монгол Улсад байнга оршин суугаа ОХУ-ын иргэдийн шимтгэлийг улсын төсвөөс төлөх шаардлагатай. Иймд 2026 оны төсөвт дээрх иргэдийн нөлөөллийг тусган оруулсан.

4. Бусад даатгуулагч болох хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого болон тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2024 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн шимтгэлийн орлого 34.2 тэрбум төгрөг, 126.4 тэрбум


төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байгаа бөгөөд зардал нь бүрдүүлж буй орлогоос 4.6 дахин их байна.

Зураг 4. Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулж буй зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



5. Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого болон тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2023 онд 616.1 тэрбум төгрөг шимтгэлийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд 192.2 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байна.


Зураг 5. Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого, ЭМДСангаас зарцуулж зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



Иймд “эв санааны зарчим”-д суурилж байгаа ч цаашид тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.2, 8.1.3-т заалтад үндэслэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

3.3.1. Улсын төсвөөс төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шилжүүлгийн зардлын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-д заасан тусламж, үйлчилгээ бүрээр гүйцэтгэлийг гаргаж, 2025 оны шилжүүлгийн хэмжээг тооцоолов.

Зураг 6.. Төр хариуцах тусламж, үйлчилгээний төсөв, гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/



3.1.4.2. Зарлагын тооцоолол

Стратегийн худалдан авагч байгууллагын хувьд даатгуулагчдад шаардлагатай эмнэл зүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг батлагдсан төсвийн хүрээнд худалдан авч, санхүүжүүлэх замаар даатгуулагчийг эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогын хүрээнд эмнэл зүйн хувьд үр дүн багатай хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ болон давхардсан оношилгоо, шинжилгээг үе шаттайгаар бууруулах, тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилтын дагуу тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, мөнгөн дүнг эрүүл мэндийн байгууллага тус бүрээр тооцоолж төлөвлөсөн.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ, оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жин, журмыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолоор шинэчлэн баталж, 2025 оны 03 дугаар сарын 07-ний өдрөөс мөрдөгдөж байна.

- Тус тогтоолын хүрээнд сангийн алдагдлыг бууруулах зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлэх тусламж, үйлчилгээг эрэмбэлэх, шаардлагагүй зарим

тусламж, үйлчилгээг хязгаарлах өөрчлөлтүүд орсон. Мөн хамтын төлбөрийн өөрчлөлт оруулах тооцоолол хийгдсэн.

Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2025 оны 03 дугаар тогтоолын дагуу өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн аргад үндэслэн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэл, үр дүнг сайжруулахад чиглэсэн дараах гол гол өөрчлөлтийг 2026 оны төсвийн төсөлд төлөвлөсөн.

- Анхан шатлалын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн үндсэн хэсэг болох “Нэг иргэнээр тооцсон” төлбөрийн аргын суурь тариф 2022 оноос хойш шинэчлэгдээгүй. Ялангуяа тухайн анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээний хүн амын тоо, үйлчилгээний чадамж зэргээс шалтгаалан 2024 оны сүүлээс эхлэн өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт хүндэрч эхэлсэн. Уг санхүүгийн хүндрэл нь хүний нөөцийн хангалтыг бууруулах, хүчин чадлыг багасгах эрсдэлийг үүсгэж байгаа тул “суурь тариф”-ыг нэмэгдүүлэх тусгасан. Ингэхдээ одоогийн тогтоолд заасан 5 насны ангиллыг 8 насны ангилал болгон өөрчлөх хувилбараар тооцооллыг боловсруулсан.
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлж буй хэвтэн эмчлүүлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, өдрийн эмчилгээ, сэргээн засах эмчилгээ, гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж болон зарим оношилгоо, шинжилгээний зардлыг 2025 оны батлагдсан төсөвт багтаахаар тооцоолсон. Ингэхдээ нэг иргэнд ногдох тусламж, үйлчилгээний зардлыг ижил байхаар нормчилж дахин хуваарилалт хийнэ гэж тооцсон.
- Одоогийн тогтоолд мөрдөгдөж буй газар зүйн коэффициент, орон нутгийн нэмэгдлийн тохируулсан индексийг, мөн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэх асуудлыг тусгасан.

Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг тооцоолохдоо шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг бууруулах, амбулаторийн тусламж, үйлчилгээ болон эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээ нэмэгдүүлэх, иргэн, даатгуулагчид эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж тооцоолсон. Үүнд:

- Хөнгөлөлттэй эмийн тусламж үйлчилгээг авч буй иргэдийн халааснаас гарах зардлыг бууруулах, архаг өвчний эмчилгээ болон түүнтэй холбогдох зардлыг анхан шат руу нь буулгах зорилгоор эмийн хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох шинэ аргачлалыг боловсруулсан болно. ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хувьд эмийг нэршил, тун, хэлбэрээр нь бүлэглэн хөнгөлөлтийн хувийг тогтоож байсан бол энэ удаагийн шинэчлэлээр эмийн үнийн интервалд суурилсан аргачлалаар бүх эмийг хамруулж хөнгөлөлтийн хувийг тооцоолсон. Тухайлбал, эмийн хөнгөлөлтийн хувь нь жагсаалтад байх нийт эмийн нэгжийн үнээс хамаарч 40-80 хүртэлх хувиар

хөнгөлөлт үзүүлэх буюу эмийн үнэ буурахад хөнгөлөлтийн хувь нэмэгдэх, даатгуулагч ижил төрлийн эмээс үнэтэйг нь сонгосон тохиолдолд илүү төлбөр төлөх гэсэн зарчимтай бодлогын өөрчлөлтийг төлөвлөсөн.

- Хөнгөлөлттэй эмийн тусламжийг авч буй нийт иргэдийн мэдээллийг хурууны хээгээр баталгаажуулах, хурууны хээгээр баталгаажуулах боломжгүй иргэдийг техник, технологийн хөгжил буюу e-mongolia, тоон гарын үсэг, бүртгэлтэй утасны дугаараар мессеж явуулж баталгаажуулах гэсэн аргуудын аль боломжтойг нь ашиглан жор бичүүлж буй иргэнээс зөвшөөрөл авах үйл явцыг шинээр нэвтрүүлэх нь эмийн зохистой хэрэглээ, иргэний эрхийг хангах, цаашлаад одоогийн буруу зан үйлээс даатгалын санг хамгаалах боломжтой.
- Үнийн дээд хязгаарыг шинэчлэн тооцоолохдоо Гаалийн ерөнхий газрын гаалийн үнийн мэдээлэл, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын импортын үнийн мэдээлэл, эмийн мэргэжлийн холбоодоос ирүүлсэн үнийн мэдээлэл, эм ханган нийлүүлэх байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн үнийн мэдээлэл, эмийн сангийн сангийн жижиглэнгийн үнийн мэдээлэл болон ЭМДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолын үнийн мэдээллийг тус тус харгалзан үзэж импортын болон дотоодын эмийн үнийн дээд хязгаарыг тооцоолох томъёоллыг шинээр боловсруулсан
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухайн хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолын дагуу эмийн хатуу зохицуулалттай орны үйлдвэрээс эсвэл олон улсын байгууллагаас эмийг төвлөрсөн байдлаар худалдан авах эрх зүйн нөхцөл бүрдсэн учраас нэг эх үүсвэрээс худалдан авч буй эмүүдийг хөнгөлөлттэй эмийн жагсаалтад оруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Солонгос улсын 5 үйлдвэрээс худалдан авахаар хэлэлцсэн 16 эмийг энэхүү тогтоолын жагсаалтын төсөлд тусган оруулсан.

Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 2023 оны зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг 5 насны бүлгээр эрт илрүүлэх 10 дугаар тогтоол, 2025 оны зонхилон тохиолдох 7 төрлийн хорт хавдрыг эрт илрүүлэх 10 дугаар тогтоолоор хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг хийхээр зохицуулсан. Үүнээс гадна ургийн болон нярайн эрт илрүүлэг, 6 насны сургуульд суурилан хийх эрт илрүүлгүүд хэрэгжүүлж байна. Эдгээр олон төрлийн эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээ нь хоорондын хамаарал бага, нэгдсэн программ хангамж байхгүй, зарим насны бүлгийг орхигдуулж байгаа, зорилтот бүлэг бус нийт хүн ам руу чиглэсэн зэрэг сул талуудтай. Иймд эдгээр сул талуудыг шийдвэрлэсэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1 дэх зорилттой уялдуулан “Үндэсний эрт илрүүлэг”-ийг хэрэгжүүлэхээр 2026 оны төсвийн төсөлд тусгасан. Уг эрт илрүүлэгт дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ураг, нярайн эрт илрүүлэг, цэцэрлэгийн насны хүүхдийн шээс, цагаан хорхой, шүдний эрт илрүүлэг, 6, 12, 15 насны хүүхдийн сургуульд суурилсан эрт илрүүлэг,

оюутны эрт илрүүлэг, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг, 18, 25, 35, 45 насанд хийх халдварт бус болон халдварт өвчний эрт илрүүлэг, зорилтот бүлэгт хийх зонхилон тохиолдох хорт хавдрын эрт илрүүлэг, ахмадын эрт илрүүлгээс бүрдсэн цогц эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг хийнэ.

- Үүнээс гадна ажиллагсдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг багтаасан нэгдсэн мэдээллийн санг бий болгоно
- Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага эрт илрүүлгийг зохион байгуулах үндсэн нэгж болно.
- Оношийн хамааралтай бүлгийн дагуу амбулаторийн санхүүжилтэд хамаарч байгаа “Эрүүл мэндэд нөлөөлөгч хүчин зүйлийн үзлэг” буюу “Z” оноштой лавлагаа шатлалын үзлэгүүдийг эрт илрүүлэх үзлэг рүү шилжүүлнэ.

ЭМДҮЗ, ЭМДЕГ-ын үйл ажиллагааны зардлыг ажиллах бүтэц, орон тоо, үйл ажиллагааны хамрах хүрээнд уялдуулан тооцсон.

3.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН 2025 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд сангийн орлогыг 2,514.8 тэрбум төгрөгөөр, зарлагыг 2,293.9 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд хасах тодотгол хийгдсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны орлого:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэл болон цалингийн сангийн мэдээлэлд үндэслэн тооцоход 2,267.0 тэрбум төгрөг гарахаар байна.

Хүснэгт 10. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	НЭР ТӨРӨЛ	2024 оны гүйцэтгэл	2025 оны батлагдсан төсөв	2025 оны Тодотгосон төсөв	2025 оны ХБГ	Зөрүү (Батлагдсан төсөв- Гүйцэтгэл)
ОРЛОГО		1,922,228.8	2,514,881.7	2,469,326.3	2,221,502.9	247,823.4
1.1	Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого	812,662.2	1,145,715.8	1,145,715.8	893,928.4	251,787.4
1.2	Шимтгэлээ өөрөө хариуцан төлөгч (хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, оюутан)	34,684.8	49,831.5	49,831.5	49,831.5	-
1.3	Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	324,113.0	353,036.7	352,203.1	352,203.1	-
1.4	Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	746,804.8	966,297.8	921,575.9	921,575.9	-
1.5	Бусад орлого акт, торгууль	3,964.0	-		3,964.0	-3,964.0

Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого эхний 6 сарын байдлаар 492.7 тэрбум төгрөг төвлөрөхөөс 423.0 тэрбум төгрөг төвлөрч 69.7 тэрбум төгрөг дутуу байна. Цаашид он дуустал хүлээгдэж буй гүйцэтгэлээр тооцоход 251,7 тэрбум төгрөгөөр орлого тасрах эрсдэлтэй байна. Мөн өмнө онуудын ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн авлага 89,6 тэрбум төгрөг байгааг Нийгмийн даатгалын ерөнхий газартай уулзаж барагдуулах арга хэмжээг авах хэрэгтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны зарлага:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны батлагдсан зарлага 2,293.9 тэрбум төгрөг ба тодотголоор 2,242.4 тэрбум төгрөгөөр болж 51,5 тэрбум төгрөгөөр буурсан ба 2025 оны дуустал сангийн зарлагын хүлээгдэж буй гүйцэтгэл 1,410,4 тэрбум төгрөг байхаар байна.

Хүснэгт 11. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Тусламж, үйлчилгээний төрөл	2024 оны гүйцэтгэл	2025 оны Батлагдсан төсөв	2025 оны тодотгосон төсөв	2025 оны ХБГ	Зөрүү /тод/
1	Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ	1,457,408.0	1,210,853.0	1,162,135.8	1,410,496.0	-248,360.2
2	Анхан шат тусламж, үйлчилгээ	487,458.8	533,396.4	533,396.4	533,396.4	
2.1.	Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээ	345,502.5	415,980.9	415,980.9	415,980.9	
2.2.	СТЭМТ-өөс үзүүлэх тусламж, үйлчилгээ	86,933.7	69,105.2	69,105.2	69,105.2	
2.3.	ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 тусламж, үйлчилгээ	55,022.6	48,310.3	48,310.3	48,310.3	
3	Эмийн үнийн хөнгөлөлт	137,801.6	171,485.3	171,086.6	201,984.1	- 30,897.5
3.1	Эмийн үнийн хөнгөлөлт		130,495.8	130,097.2	155,399.1	- 25,301.9
3.2	Төр төлбөрийг нь хариуцах эм		40,989.5	40,989.5	46,585.0	- 5,595.5
4	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	31,619.7	40,000.0	40,000.0	40,000.0	
5	Өмнөх оны өглөг	218,317.3	315,160.1	316,838.6	316,838.6	
6	Үйл ажиллагааны зардал	15,049.5	17,811.0	13,790.3	13,790.3	
7	ЭМД-ын шимтгэлийн илүү төлөлтийн буцаалт	25.6	200.0	199.5	199.5	
8	ЭМБ-д олгох урамшууллын зардал		5,000.0	5,000.0	5,000.0	
Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага		2,347,680.0	2,293,906.0	2,242,447.3	2,521,705.0	-279,257.7
Үүнээс олгосон		2,030,841.7			2,242,447.3	
Өглөг		316,838.6			- 279,257.7	

Зарлагын хэтрэлтийн шалтгаан:

1. 2025 оны батлагдсан зарлагаас он дамжсан 316.8 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.
2. ЭМДҮЗ тогтоол 3 сарын 7-оос хэрэгжүүлсэн бөгөөд 2024 оны 12 сарын 10-аас 2025 оны 3 сар хүртэлх хугацааны тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, мөнгөн дүнгийн хэтрэлт - 15,7 тэрбум төгрөг байна.
3. Мөн тогтоолд тусгагдсан заалтын дагуу цочмог, төлөвлөгөөт тусламж, үйлчилгээ байгуулсан гэрээний дүнгээс нэхэмжлэл хэтэрч орж ирж байгаа хэтрэлтийг он дамжуулан санхүүжүүлэхээр байна.
4. Мөн энэ оны батлагдсан төсөвт суугдаагүй “Эрүүл хүүхэд” арга хэмжээ, Улаанбурханы өвчлөл, үндэсний багийн тарифын дэмжлэг зэрэг арга хэмжээний нөлөөллүүд байна.
5. ЗГ-ын 132 дугаар тогтоолоор үйлчилгээний тариф нэмэгдүүлэх шийдвэр гаргахыг хориглосонтой холбоотой оны эхэнд ОХБ-ын хамтын төлбөрт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байсан бөгөөд 86,1 тэрбум төгрөгийн нөлөөлөл үүсэхээр байна.

3.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

3.3.1. Сангийн 2026 оны төсвийн тэнцэл

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөлд сангийн орлогыг 3,055.3 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагыг 3,023.0 тэрбум төгрөгөөр, сангийн тэнцэл 32.2 тэрбум төгрөгийн ашигтай байхаар тус тус төлөвлөв. Энэ нь 2025 оны батлагдсан төсвөөс /тодотгол/ орлого 585.9 тэрбум төгрөгөөр (23.7%), зарлага 801.2 тэрбум төгрөгөөр (35.7%) нэмэгдэж байна.

Хүснэгт 12. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл /сая төгрөгөөр/

№	САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2024 он	2025 он			2026 он
		Гүйцэтгэл	Батлагдсан	Тодотгосон	ХБГ	Төсөл
1	А. ОРЛОГО	1,921,743.4	2,514,881.7	2,469,326.3	2,221,502.9	3,055,311.0
2	Б. ЗАРЛАГА	2,347,680.3	2,293,906.3	2,242,447.3	2,521,705.0	3,043,675.7
3	САНГИЙН ТЭНЦЭЛ (ОРЛОГО-ЗАРЛАГА)	(425,936.9)	220,975.4	226,879.0	(300,202.1)	11,635
4	КАПИТАЛ БАНКНААС АВАХ ЭМДСАНГИЙН АВЛАГА	(85,000.0)	(77,600.0)	(77,600.0)	(77,600.0)	(70,000)

3.3.2. Сангийн орлого

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөлд нийт 3,055.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 37.0 хувь буюу 1,131.1 тэрбум төгрөгийг ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 21.3 хувь буюу 653.2 тэрбум төгрөгийг төр хариуцах иргэдийн шимтгэлийн орлогоос, 1,8 хувь буюу 57.5 тэрбум төгрөгийг шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 39.2 хувь буюу 1,198.1 тэрбум төгрөгийг төр хариуцах тусламж, үйлчилгээний улсын төсвийн орлогоос, 0.5 хувь буюу 15.2 тэрбум төгрөгийг бусад орлогоос бүрдүүлэхээр тус тус төлөвлөв.

Хүснэгт 13. Сангийн орлого /сая төгрөгөөр/

Төсвийн үзүүлэлт		2025 он			2026 он		
		Батлагдсан төсөв	Тодотгосон	ХБГ	Төсвийн төсөл	Зөрүү (2025-2024)	Зөрүү /хувиар/
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ-А. ОРЛОГО		2,514,881.7	2,469,326.3	2,221,502.9	3,055,311.0	585,984.7	23.7%
1	Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	1,145,715.8	1,145,715.8	893,928.4	1,131,158.1	-14,557.7	-1.3%
2	Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	353,036.7	352,203.1	352,203.1	653,269.8	301,066.7	85.5%
3	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	49,831.5	49,831.5	49,831.5	57,540.1	7,708.6	15.5%
4	Бусад орлого	-		3,964.0	15,200.6	15,200.6	
5	Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	966,297.8	921,575.9	921,575.9	1,198,142.5	276,566.6	30.0%

3.3.3. Сангийн зарлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөлд нийт 3,043.6 тэрбум төгрөгийн зарлагаас 87.5 хувь буюу 2,663.6 тэрбум төгрөгийн эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний зардалд, 7.8 хувь буюу 237.7 тэрбум төгрөгийг эмийн хөнгөлөлтийн зардалд, 0.6 хувь буюу 20.0 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 4.0 хувь буюу 122.2 тэрбум төгрөгийг эрсдэлийн сангийн зардал тус тус зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 14. Сангийн зарлага /сая төгрөгөөр/

№	Тусламж, үйлчилгээний төрөл	2024 оны гүйцэтгэл	2025 оны Батлагдсан төсөв	2025 оны Тодотгосон төсөв	2025 оны ХБГ	2026 оны төсвийн төсөл
1	Лавлагаа шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1,457,408.0	1,210,853.0	1,162,135.8	1,410,496.0	1,560,065.7
2	Анхан шат тусламж, үйлчилгээ	487,458.8	533,396.4	533,396.4	533,396.4	720,587.8
2.1.	Нэг иргэнээр тооцсон тусламж, үйлчилгээ	345,502.5	415,980.9	415,980.9	415,980.9	603,172.2
2.2.	СТЭМТ-өөс үзүүлэх тусламж, үйлчилгээ	86,933.7	69,105.2	69,105.2	69,105.2	69,105.2
2.3.	ӨСТЭМТ-өөс үзүүлэх 4 тусламж, үйлчилгээ	55,022.6	48,310.3	48,310.3	48,310.3	48,310.3
3	Эмийн үнийн хөнгөлөлт	137,801.6	171,485.3	171,086.6	201,984.1	237,722.5
3.1	Эмийн үнийн хөнгөлөлт		130,495.8	130,097.2	155,399.1	186,479.0
3.2	Төр төлбөрийг нь хариуцах эм		40,989.5	40,989.5	46,585.0	51,243.5
4	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг	31,619.7	40,000.0	40,000.0	40,000.0	98,277.6
5	Эрсдэлийн сан		-			122,212.4
6	Өмнөх оны өглөг	218,317.3	315,160.1	316,838.6	316,838.6	279,257.7
7	Үйл ажиллагааны зардал	15,049.5	17,811.0	13,790.3	13,790.3	20,072.0
8	ЭМД-ын шимтгэлийн илүү төлөлтийн буцаалт	25.6	200.0	199.5	199.5	480.0
9	ЭМБ-д олгох урамшууллын зардал;		5,000.0	5,000.0	5,000.0	5,000.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарлага		2,347,680.0	2,293,906.0	2,242,447.3	2,521,705.0	3,043,675.8
Үүнээс олгосон		2,030,841.7			2,242,447.3	
Өглөг		316,838.6			279,257.7	

1. Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас 2025 оны батлагдсан төсөвт багтаан, зардлыг үр ашигтай зарцуулах зорилгоор тусламж, үйлчилгээний тоо хэмжээг 2024 оны гүйцэтгэлийн тоо хэмжээнээс нэмэгдүүлэлгүй, зарим тусламж, үйлчилгээний тоо хэмжээг бууруулан, гэрээ байгуулан ажиллаж байгаа билээ. 2026 онд өмнөх оны өглөгийг бүрэн олгохоор төлөвлөсөнтэй холбоотойгоор мөнгөн урсгалын тооцооллыг хийж, зарим тусламж, үйлчилгээний өртгийг нарийвчлан тооцох, мөн зарим тусламж, үйлчилгээг анхан шатны тусламж, үйлчилгээ рүү шилжүүлэх замаар тохиолдлын тоог 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс хэтрүүлэхгүй байхаар тооцож, тарифыг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр тооцов.

2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх нэг иргэнээр тооцсон тарифыг насны бүлэгтэй нь уялдуулан шинэчлэн боловсруулан, батлагдсан төсвөөс Төсвийн хязгаарын саналтай уялдуулан 187.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцов. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үзүүлдэг бусад тусламж, үйлчилгээг энэ оны батлагдсан төсвөөс нэмэгдүүлэхгүй байхаар тооцоолов. Анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, 2022 оноос хойш нэмэгдүүлээгүй суурь тарифт өөрчлөлт оруулах бодлогыг нарийвчлан тодорхойлох, юу хийдэгт нь бус юу хийх ёстойд нь нийцүүлж “Хаалга баригч”-ийн үүргийг нь биелүүлэх дэмжлэгт орчин бүрдүүлэх зэрэг бодлогын арга хэмжээний суурийг тавихад уг төсвийн нэмэгдэл чухал алхам болно гэж үзсэн.

3. Эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ нь гүйцэтгэлийн санхүүжилтийн бодлогын чухал хэсэг бөгөөд амбулаторийн тусламж, үйлчилгээг дэмжиж, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлэгт хэвтэлтийг бууруулахад чухал үүрэгтэй. Мөн ДЭМБ хийсэн судалгаанаас үзвэл хувь хүний халааснаас эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа төлж буй төлбөрийн 68 хувийг эмийн зардал эзэлж байна. ЭМД-ын хөнгөлөлт, хүртээмж сайжирсан хэдий ч хязгаарлагдмал өвчнүүд дээр хөнгөлөлт хийж буй учраас хөнгөлөлтөд ороогүй эмүүдийг иргэд халааснаас төлсөн хэвээр байна. Иймд тус үйлчилгээний нэр төрлийг илүү нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд тусгав. Түүнчлэн төлбөрийг төр хариуцах эмийг эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд багтаан оруулан тооцов.

4. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоог цаашид “Үндэсний эрт илрүүлэг”-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 98.3 тэрбум төгрөг буюу энэ оны батлагдсан төсвөөс 58.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн. Ураг, нярай, цэцэрлэг, сургуульд суурилсан, оюутан, цэрэг, зорилтот насанд хийх халдварт бус болон халдварт өвчин, зорилтот бүлэгт хийх зонхилон тохиолдох хорт хавдар, ахмад гэсэн нийт 9 төрлийн эрт илрүүлгээс бүрдсэн багцуудыг хэрэгжүүлэхээр тооцов.

5. ЭМД-ын тухай хуульд заасны дагуу сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувиар эрсдэлийн санг байгуулахаар хуульчилсан. 2024 оны ХБГ ээс үзвэл өмнөх оны өглөг болон тусламж, үйлчилгээ тоо, хэмжээнээс өсөлтөөс шалтгаалж эрсдэлийн сан нь бүрэн зарцуулагдахаар байна. 2026 оны эрсдэлийн сангийн хөрөнгийн хэмжээг МУЗГ-н ы үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу, 2026 оны эрүүл мэндийн даатгалын орлогын төсвийн 5 хувиар тооцон төлөвлөв.

6. 2023 онд эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлж буй нэхэмжлэлийн тоо хэмжээ өссөнөөс (37%) шалтгаалж зардал батлагдсан төсвөөс 218.3 тэрбум төгрөг, 2024 онд өссөн дүнгээр 316.8 тэрбум төгрөгийн өглөгтэй гарсан. 2025 онд зарим тусламж, үйлчилгээг хязгаарлах замаар эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ оны зардлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр зарлага батлагдсан төсвөөс 279.2 тэрбум төгрөгөөр давахаар байна. 2026 онд сангийн хуримтлагдсан өр төлбөрийг дарах шаардлагатай гэж үзэж, төсвийн төсөлд тусгалаа.

7. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг нэхэмжлэлийн хяналтын хүрээг мэргэжлийн эмч шинжээч нарын оролцоотойгоор өргөжүүлж олон улсад хийдэг жишигт хүргэх, Uptodate олон улсын эмнэл зүйн удирдамжийг үргэлжлүүлэх, ЭМД-ын цахим системийг

өргөжүүлэх, нэхэмжлэлийн цахим хяналтыг бий болгож, цахим системийг өргөжүүлэх, ЭМД-н албан хаагчдын цалингийн өсөлттэй, ажлын үр дүнд уялдсан бүтээмжийн урамшуулал олгох, мөн бусад зардлыг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэв.

8. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.13-т заасан "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад энэ хуулийн 20.1.3-т заасан урамшуулал олгох журмыг батлах" гэсэн заалтын дагуу 5 тэрбум төгрөгөөр төсөвлөв.

3.3.4. Үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй

3.3.4.1. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын 2026 оны төсвийн төслийг 2025 оны батлагдсан төсвөөс 1.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 18.8 тэрбум төгрөгөөр төлөвлөв.

Хүснэгт 15. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны 2026 оны төсвийн төсөл /мян.төгрөгөөр/

Зардлын зүйл	Мөр	2025 оны төсөв	Төсвийн төсөл 2026 он	Зөрүү
1. Урсгал зардал /2+42/	1	16,892,853.2	18,883,367.3	1,990,514.1
1.1 Бараа, ажил, үйлчилгээний зардал /3+8+14+19+24+27+29+39/	2	16,328,027.8	18,311,537.9	1,983,510.1
1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил /4+5+6+7/	3	8,926,237.7	10,067,403.6	1,141,165.9
1.1.1.1 Үндсэн цалин хөлс	4	5,300,800.7	5,414,045.5	113,244.8
1.1.1.2 Нэмэгдэл	5	1,922,205.4	1,999,454.7	77,249.3
1.1.1.3 Унаа хоолны хөнгөлөлт	6	669,829.7	826,799.9	156,970.2
1.1.1.4 Урамшуулал	7	1,033,401.9	1,827,103.4	793,701.5
1.1.2 Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	8	1,132,124.7	1,166,200.6	34,075.9
1.1.2.1 Тэтгэврийн даатгал	9	769,844.8	786,289.1	16,444.3
1.1.2.2 Тэтгэмжийн даатгал	10	90,570.0	94,977.9	4,407.9
1.1.2.3 ҮОМШ өвчний даатгал	11	45,285.0	47,488.8	2,203.8
1.1.2.4 Ажилгүйдлийн даатгал	12	45,285.0	47,488.9	2,203.9
1.1.2.5 Эрүүл мэндийн даатгал	13	181,139.9	189,955.9	8,816.0
1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал /15+16+17+18/	14	205,225.2	211,612.5	6,387.3
1.1.3.1 Гэрэл цахилгаан	15	63,765.0	75,034.1	11,269.1
1.1.3.2 Түлш, халаалт	16	67,885.2	44,027.3	- 23,857.9
1.1.3.3 Цэвэр, бохир ус	17	24,525.0	37,517.1	12,992.1
1.1.3.4 Байрны түрээс	18	49,050.0	55,034.1	5,984.1
1.1.4 Хангамж, бараа материалын зардал /20+21+22+23/	19	236,380.2	255,763.4	19,383.2
1.1.4.1 Бичиг хэрэг	20	59,806.7	64,710.8	4,904.1
1.1.4.2 Тээвэр шатахуун	21	18,946.4	20,500.0	1,553.6
1.1.4.3 Шуудан холбоо интернэтийн төлбөр	22	78,480.0	84,915.4	6,435.4
1.1.4.4 Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс худалдан авах	23	79,147.1	85,637.2	6,490.1
1.1.5 Эд хогшил, урсгал засварын зардал /25+26/	24	83,670.0	458,277.8	374,607.8
1.1.5.1 Багаж, техник, хэрэгсэл	25	44,430.0	413,073.3	368,643.3

1.1.5.2 Урсгал засвар	27	39,240.0	45,204.5	5,964.5
1.1.6 Томилолт, зочны зардал /28/	28	127,530.0	148,189.9	20,659.9
1.1.6.1 Дотоод албан томилолт	29	127,530.0	148,189.9	20,659.9
1.1.7 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	30	4,921,801.0	5,092,758.7	170,957.7
1.1.7.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ	31	2,362,945.7	2,324,077.2	- 38,868.5
1.1.7.2 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	32	-	-	-
1.1.7.3 Даатгалын үйлчилгээ	33	1,962.0	2,122.9	160.9
1.1.7.4 Тээврийн хэрэгслийн татвар	34	1,962.0	2,122.9	160.9
1.1.7.5 Тээврийн хэрэгслийн оношилгоо	35	467.3	505.6	38.3
1.1.7.6 Газрын төлбөр	36	921.0	996.5	75.5
1.1.7.7 Мэдээлэл технологийн үйлчилгээ	37	2,550,600.0	2,759,749.2	209,149.2
1.1.7.8 Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	38	2,943.0	3,184.3	241.3
1.1.8 Бараа үйлчилгээний бусад зардал /40+41/	40	695,059.0	752,053.8	56,994.8
1.1.8.1 Бараа үйлчилгээний бусад зардал	41	646,499.5	699,512.5	53,013.0
1.1.8.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага	42	48,559.5	52,541.4	3,981.9
1.2 Урсгал шилжүүлэг /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг/ /43+44/	43	564,825.4	520,356.8	- 44,468.6
1.2.1 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	44	496,155.4	444,682.5	- 51,472.9
1.2.2 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45	68,670.0	75,674.3	7,004.3
1.2.3 Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтын дагуу			65,562.0	65,562.0
2. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	46	16,892,853.2	18,883,367.3	1,990,514.1
3. Эрүүл мэндийн даатгалын сангаас	47	16,892,853.2	18,883,367.3	1,990,514.1
4. Ажиллагсдын тоо	48	285.0	285.0	285.0
Удирдах ажилтан	49	38.0	38.0	38.0
Гүйцэтгэх ажилтан	50	247.0	247.0	247.0
5. Орон тооны мэдээлэл	51	285.0	285.0	285.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	52	260.0	260.0	260.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	53	25.0	25.0	25.0
6. Нийт тэтгэвэрт гарагч	54	9.0	9.0	9.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	55	9.0	9.0	9.0
Засгийн газрын 83-р тогтоолыг үндэслэн	56	8.0	8.0	8.0

3.3.4.2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардал

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлын 2026 оны төсвийн төслийг 2025 оны батлагдсан төсвөөс 270.4 сая нэмэгдүүлэн 1,188.6 сая төгрөгөөр төлөвлөв.

Хүснэгт 16. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны төсвийн төсөл
/мян.төгрөгөөр/

Зардлын зүйл	2024 он	2025 он	2026 оны төсөв
Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл	744,972.5	918,192.6	1,188,617.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	744,972.5	918,192.6	1,188,617.3
УРСГАЛ ЗАРДАЛ	744,972.5	918,192.6	1,188,617.3
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,896.9	780,001.9	1,160,617.3
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	445,485.8	495,097.1	637,191.2

Үндсэн цалин	262,480.3	305,589.4	357,848.0
Нэмэгдэл	105,368.7	110,573.9	140,029.2
Унаа хоолны Хөнгөлөлт	42,732.4	42,305.1	91,872.0
Урамшуулал	34,904.4	36,628.7	47,442.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,685.6	62,832.8	106,340.9
Тэтгэврийн даатгал	37,866.2	42,726.3	72,311.8
Тэтгэмжийн даатгал	4,454.8	5,026.7	8,507.4
ҮОМШ-ний даатгал	3,564.0	2,513.3	4,253.6
Ажилгүйдлийн даатгал	890.9	2,513.3	4,253.6
Эрүүл мэндийн даатгал	8,909.7	10,053.2	17,014.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,584.5	78,431.0	107,220.3
Гэрэл, цахилгаан	2,386.0	7,651.8	7,651.8
Түлш, халаалт	1,905.0	8,485.7	8,485.7
Цэвэр, бохир ус	1,905.0	4,905.0	5,000.0
Байрны түрээс	57,388.5	57,388.5	86,082.8
Хангамж, бараа материалын зардал	23,920.8	27,220.8	10,500.0
Бичиг хэрэг	6,619.8	6,619.8	-
Тээвэр, шатахуун	2,943.0	2,943.0	4,500.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,586.0	5,886.0	6,000.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,772.0	11,772.0	-
Эд хогшил, урсгал засварын зардал	11,629.0	8,829.0	56,243.5
Багаж, техник, хэрэгсэл	11,629.0	8,829.0	56,243.5
Тавилга	-	-	-
Томилолт, зочны зардал	22,612.0	22,612.0	33,918.0
Дотоод албан томилолт	22,612.0	22,612.0	33,918.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,121.3	69,121.3	5,150.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,334.6	65,334.6	-
Мэдээллийн технологийн үйлчилгээ	3,433.5	3,433.5	5,150.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	353.2	353.2	-
Бараа үйлчилгээний бусад зардал	15,857.9	15,857.9	204,053.3
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	180,266.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,857.9	15,857.9	23,786.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,075.6	138,190.7	28,000.0
Тэтгэвэрт гарах мөнгөн урамшуулал		111,115.1	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,075.6	27,075.6	28,000.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	744,972.5	918,192.6	1,188,617.3
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	744,972.5	918,192.6	1,188,617.3
АЖИЛЛАГСДЫН ТОО	12.0	12.0	12.0
Удирдах ажилтан	1.0	1.0	1.0
Гүйцэтгэх ажилтан	11.0	11.0	11.0

3.4. САЛБАРЫН 2027, 2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026-2027 оны Төсвийн төсөөллийг “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөв.

Хүснэгт 17. Төсвийн төсөөлөл /сая төгрөгөөр/

Төсвийн үзүүлэлт			2026 он	2027 он	2028 он
			Төсвийн төсөл	Төсвийн төсөөлөл	
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ - А. ОРЛОГО			3,055,311.0	3,269,182.8	3,484,948.9
	1.	Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл	1,131,158.1	1,210,339.2	1,290,221.6
	2.	Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	653,269.8	698,998.7	745,132.6
	3.	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	57,540.1	61,567.9	65,631.4
	4.	Бусад орлого	15,200.6	16,264.6	17,338.1
	5.	Төр хариуцах тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс олгох хөрөнгө	1,198,142.5	1,282,012.4	1,366,625.3
Б. ЗАРЛАГА			3,043,675.7	3,256,532.2	3,447,787.9
	1.	Эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний санхүүжилт	2,663,668.8	2,850,125.6	3,038,233.9
		1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,465,526.3	1,568,113.1	1,671,608.6
		1.2 Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,198,142.5	1,282,012.4	1,366,625.3
	2	Эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд	237,722.5	254,363.0	271,151.0
	3	Үйл ажиллагааны урсгал зардал	20,072.0	21,276.3	22,552.9
	4	Эрсдэлийн сан	122,212.4	130,767.3	139,398.0
С. САНГИЙН ТЭНЦЭЛ (ОРЛОГО-ЗАРЛАГА)			11,635.4	12,650.6	13,613.2